

Дорноговь аймаг дахь
төрийн аудитын газар

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН | 2021

АГУУЛГА

ХУРААНГУЙ ТАЙЛАН	3-5
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	5-6
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	6-9
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	10-12
НИЙЦЛИЙН АУДИТ	13
БУСАД АУДИТ	13-19
ДОТООД АЖИЛ	19-24
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	25
ДҮГНЭЛТ, САНАЛ	25-26
ХАВСРАЛТ	

ХУРААНГУЙ ТАЙЛАН:

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/105 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах журам”-ын дагуу Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны үйл ажиллагааг тайлагнаж байна.

Статистик мэдээлэл:

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь санхүүгийн тайлангийн аудит 221, ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудит 1, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэл” аудит 1, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит 4, өөрийн санаачилгат гүйцэтгэлийн аудит 3, нийцлийн аудит 1, өмнө онд дуусгаагүй нийцлийн аудит 1, эрсдэлийн аудит 1, нийт 233 аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудитыг хослуулан хийж гүйцэтгэлээ.

Тайлант онд нийт 54,458.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 29.9 сая төгрөгийн 22 төлбөрийн акт тогтоож, 5,788.2 сая төгрөгийн 87 албан шаардлага, 11,356.5 сая төгрөгийн 303 зөвлөмжийг хүргүүлж, 4.7 сая төгрөгийн 1 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэж, 37,278.7 сая төгрөгийн алдааг залрууллаа. /Хүснэгт №1/

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 онд тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн бүртгэл

/Хүснэгт №1/

№	Үзүүлэлт	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хуулийн байгууллагад шилжүүлэх		Залруулга		Хариуцлага тооцуулах санал		Нийт дүн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн аудит	22	22.7	67	3,260.0	236	6,507.6	1	4.7	413	37,278.7	2		741	47,073.7
2	Гүйцэтгэлийн аудит	2	7.2	20	2,528.2	59	4,848.9					2		83	7,384.3
3	Нийцлийн аудит													0	-
Дүн		24	29.9	87	5,788.2	295	11,356.5	1	4.7	413	37,278.7	4	0	824	54,458.0

Үүнээс төлбөрийн акт 95 хувийн, албан шаардлага 79 хувийн, зөвлөмж 63 хувийн хэрэгжилттэй байна.

Мөн өмнөх оны үлдэгдэл 25.7 сая төгрөгийн 22 төлбөрийн акт, 7,382.4 сая төгрөгийн 40 албан шаардлага, 11,332.5 сая төгрөгийн 118 зөвлөмж байна. Үүнээс тайлант онд төлбөрийн акт 23 хувь, албан шаардлага 55 хувьтай, зөвлөмж 57 хувьтай хэрэгжсэн.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:

Товчилсон үг	Тайлбар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗШЭ	Зайлшгүй шаардлагатай эм
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НДС	Нийгмийн даатгалын сан
ОБГ	Онцгой байдлын газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАГ	Төрийн аудитын газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨААН	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ТЖА	Төрийн жинхэнэ албан хаагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхлын, хөрөнгө орлогын мэдүүлэг
ХМХА	Хилийн мэргэжлийн хяналтын алба
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ШТА	Шууд тайлагналын аудит
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ЭМГ	Эрүүл мэндийн газар

Дэвшүүлсэн зорилтын биелэлт:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/09 тушаалаар Төрийн аудитын байгууллагын 2021 оны зорилтыг “Аудитыг цахимжуулж нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх” гэж тодорхойлсон.

Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг УАГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу боловсруулан гаргасан.

Тайлант онд ТШЗ-ын санхүүгийн тайланд хийсэн 104 аудитын тайлан, ОНӨК-уудын санхүүгийн тайланд хийсэн 8 аудитын тайлан, ТТЗ-ын санхүүгийн тайланд хийсэн 14 аудитын тайлан, ТЕЗ-ын санхүүгийн тайланд хийсэн 1 аудитын тайлан, ТЕЗ-ын төсвийн гүйцэтгэлд хийсэн 1 аудитын тайлан, нийцлийн аудитын 1 тайлан, гүйцэтгэлийн аудитын 4 тайлан буюу 133 аудитын тайланг www.tailan.audit.mn цахим хуудаст тухай бүр байршуулсан.

Тайлант оны 9, 10 дугаар саруудад УАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн 3 гүйцэтгэлийн аудитын тайланг аудитын нэгдсэн тайлан баталгаажих хүртэлх хугацаанд цахим хуудсанд байршуулахгүй байх чиглэл өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхдээ бүх үе шатны хяналтыг www.staus.audit.mn программд цахимаар хэрэгжүүлж ажиллаа.

Цар тахал “Ковид-19” халдварын хөл хорионы үед 2021 оны 5, 6 дугаар саруудад албан хаагчдыг ажлын байранд болон цахимаар ажиллах хуваарь гарган ажиллаа.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд цахимаар нэгэн зэрэг зохион байгуулсан тангараг өргөх ёслолын ажиллагаанд 6 албан хаагч хамрагдаж, тангараг өргөсөн.

Тайлант онд тогтоосон 20 төлбөрийн акт, 87 албан шаардлага, 53 тушаал шийдвэрийг нэгтгэн цахим файлын сан үүсгэсэн.

Аудитын ажлын баримт, байгууллагын статистик мэдээг файл болгон зөөврийн хатуу дискэнд хуулж цахим архив үүсгэлээ.

Үндэсний аудитын газар нь аудиторуудын чадавхыг бэхжүүлэх зорилгоор цахим сургалтын системийг хөгжүүлэн, нэвтрүүлсэн. Тус системийн э-хичээл болох “Төрийн аудитын тухай хуулийн хэрэглээ” цахим сургалтад 1 албан хаагч, “Эдийн засгийн бодлогын шинжилгээ” сэдэвт цахим сургалтад 6 албан хаагч хамрагдаж, сорил шалгалтыг амжилттай өгсөн.

Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан зарим сургалтад тусгаарлалтад байсан албан хаагч онлайнаар /googlemeet/ хамрагдсан.

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар хийгдсэн “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”, “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт”, “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитуудын нээлтийг цахим хэлбэрээр зохион байгуулсан.

Үндэсний аудитын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу шаардлагатай мэдээ, судалгааг гарган тухай бүх цахимаар хүргүүлж ажиллаа.


Байгууллагын санхүүгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн мэдээлж ажилласан.

Аудитын үр өгөөж:

Тайлант онд нийт 1,712.6 сая төгрөгийн үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд нэг төгрөг ногдох үр өгөөж 3.96 төгрөг байна.

Өмнөх оны төлөвлөсөн болон тайлант онд гүйцэтгэсэн аудитаар нийт 712.6 сая төгрөгийн үр өгөөжийг холбогдох байгууллага албан тушаалтнаар хүлээн зөвшөөрүүлж ажиллаа.

Мөн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “..., аймгийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэж заасны дагуу орон нутгийн 2022 оны төсвийн төсөлд газрын төлбөрийн орлогыг 2,299.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүргүүлж, 1,000.0 сая төгрөгийн орлогыг төсвийн төсөлд тусгуулан, батлуулсан.



НЭГ: УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/02 дугаар тушаалаар “Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл”, А/19 дүгээр тушаалаар аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын орон тоо, албан тушаалын жагсаалт шинэчлэн батлагдсан.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар 2021 онд нийт 13 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явууллаа.

Үүнээс үндсэн орон тооны 11 ажилтан, гэрээт 3 ажилтан ажиллаж байна. Тайлант онд 3 аудитор шинээр томилогдон, 1 ахлах аудитор шилжиж, 1 ахлах аудитор хүүхэд асрах чөлөөтэй байна.



Тус газар нь 2021 онд нийт 1182 хүн/өдөр, 3316 илүү цагаар ажиллаж, батлагдсан бүтцийн хүрээнд дэмжих үйлчилгээний нэгжид, дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер, жолооч, бичиг хэрэг, үйлчлэгч тус бүр 1, төрөлжсөн аудит хариуцсан 3 нэгжид ахлах аудитораар 1, аудитораар 7, гэрээт аудитораар 1 ажилтан тус тус ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллагын 2021 онд дэвшүүлсэн “Аудитыг цахимжуулж нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх” зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, стратегийн хүрээнд нийт 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсний дагуу бүрэн хэрэгжүүлж ажиллаа.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “..., аймгийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн




Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэж заасны дагуу орон нутгийн 2022 оны төсвийн төсөлд газрын төлбөрийн орлогыг 2,299.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заагдаагүй 520.0 сая төгрөгийн зарлагыг бууруулах санал бүхий дүгнэлт гарган аймгийн ИТХ-д хүргүүллээ. Үүнээс 1,000.0 сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлэхээр төсвийн төсөлд тусгуулан ажиллаа.

ХОЁР: САНХҮҮГИЙН АУДИТ



Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 221 байгууллага, тусгай сангуудыг аудитад хамруулахаас 15 байгууллагад итгэл үзүүлэн, нийт 206 төсөв захирагч, сан, ТБОНӨААН-ийн 2020 оны санхүүгийн тайланд аудит хийлээ. Үүнээс 47.5 хувь буюу 98 тайланг Төрийн аудитын газар, 52.5 хувь буюу 108 тайланг хувийн аудитын 3 компаниар гүйцэтгүүллээ.



Санхүүгийн тайлангийн аудитыг ТАГ-ын 5 аудитор, 2 гэрээт аудитораар гүйцэтгэж, 798 хүн-өдөр, 1092 илүү цаг ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/81 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг үндэслэн хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулж “Ингүүмэл жаргалант аудит” ХХК, “Есөн хангай аудит” ХХК, “Гэрэлт хөхийн тэнцвэр” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллав.

Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 14, төсвийн шууд захирагчийн 106, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 8, засгийн газрын тусгай сангийн 4, нийт 133 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, төсвийн шууд захирагчийн 44, сангийн 29, тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж гүйцэтгэлээ.



Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 47,073.7 сая төгрөгийн 739 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 37,278.7 сая төгрөгийн 413 алдааг залруулж, 22.7 сая төгрөгийн зөрчилд 20 төлбөрийн акт тогтоон, 3,260.0 сая төгрөгийн зөрчилд 67 албан шаардлага, 6,507.6 сая төгрөгийн зөрчилд 236 зөвлөмжийг тус тус хүргүүллээ. Мөн өмнөх оны албан шаардлага хэрэгжүүлээгүй, төлбөрийн актыг барагдуулаагүй 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 4.4 сая төгрөгийн 1 зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлэх саналыг Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлсэн.

Төсвийн шууд захирагчийн тайлан

Аудитад төсвийн шууд захирагчийн 165, сум хөгжүүлэх сангийн 14, орон нутгийн хөгжлийн сангийн 15, нийт 194 санхүүгийн тайланг хамруулахаас 15 байгууллагын

санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 179 төсвийн шууд захирагчийн 2020 оны санхүүгийн тайланг аудит хамрууллаа. Үүнээс 106 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 73 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэлээ. Тус аудитаар 101 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 4 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Түүвэр аудитад Сайншанд сумын Захирагчийн ажлын алба, аймгийн МССТ, 12 сумын ИТХ, 14 сумын соёлын төв, 26 цэцэрлэг, орон нутгийн хөгжлийн 15 сан, сум хөгжүүлэх 14 нийт 62 байгууллагыг хамруулахаар төлөвлөн, бүрэн хэрэгжүүлсэн.

Тус аудитаар 5 ТШЗ-ийн тайланд зөрчилтэй дүгнэлт гарснаас Сайншанд сумын ИТХ, Алтанширээ сумын ЗДТГ, Орон нутгийн өмчийн газар, Сайншанд сумын 7-р цэцэрлэгт тус тус “Хязгаарлалттай” санал дүгнэлт, мал эмнэлгийн газарт “Сөрөг” санал дүгнэлтийг тус тус өгөв.

Санхүүгийн аудитын тайлангийн 95 ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитыг төрийн аудитын байгууллага, 99 ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитыг хувийн аудитын компани хийж гүйцэтгэсэн.

Төсвийн шууд захирагчийн тайланд 28,981.7 сая төгрөгийн 664 алдаа, зөрчил илрүүлж, 24,219.2 сая төгрөгийн 391 алдааг аудитын явцад залруулж, 22.7 сая төгрөгийн зөрчилд 20 төлбөрийн акт тогтоож, 3,064.8 сая төгрөгийн зөрчилд 61 албан шаардлага хүргүүлж, 1,670.3 сая төгрөгийн зөрчилд 189 зөвлөмж өгч, өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй болон төлбөрийн актыг барагдуулаагүй 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, 4.7 сая төгрөгийн зөрчилтэй 1 байгууллагыг хуулийн байгууллагад шилжүүлэхээр холбогдох баримтыг Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлэв.

Тайлант хугацаанд тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжөөс 6.2 сая төгрөгийн 16 төлбөрийн акт барагдаж, 2664.8 сая төгрөгийн 32 албан шаардлага, 508.3 сая төгрөгийн 44 зөвлөмж хэрэгжсэн байна. Нийт 1,135.0 сая төгрөгийн 139 акт албан шаардлага, зөвлөмжийн хугацаа болоогүй хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Өмнөх оны эхний хагас жилийн статистик мэдээгээр хугацаа хэтэрсэн 3821.2 сая төгрөгийн 157 акт, албан шаардлага, зөвлөмж байсан бол тайлант онд 1,815.5 сая төгрөгийн 123 төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх үетэй харьцуулахад 2,005.7 сая төгрөг буюу 52.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан

Аудитад 14 сумын санхүүгийн нэгтгэсэн тайланг хамруулахаас бүрэн хамруулж “Зөрчилгүй” санал дүгнэлтийг өглөө. Тайлант хугацаанд Засгийн газрын ХЭДС, НДС, Халамжийн сан /орон нутаг/, Халамжийн сан/улсын төсөв/-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийхээр төлөвлөн, бүрэн хэрэгжүүлж 4 тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

Сумдын 14 төсвийн төвлөрүүлэн захирагч, ХЭДС, НДС-ийн санхүүгийн тайлангийн нийт 16 аудитыг төрийн аудитын байгууллага, Халамжийн сан /орон нутаг/, Халамжийн сан/улсын төсөв/-ийн санхүүгийн тайлангийн аудитыг хувийн аудитын компани тус тус гүйцэтгэлээ.

Аудитаар илэрсэн зөрчлийг ангилан харуулбал:

- Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 17.0 сая төгрөгийн 2 алдаа

- Орлого бүрдүүлэлттэй холбоотой 3 зөрчил,
- Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой холбоотой 3 зөрчил.
- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 6 зөрчил

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 118.6 сая төгрөгийн 14 алдаа зөрчил илрүүлж, 17.0 сая төгрөгийн 2 алдааг залруулан, 1.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, 100.1 сая төгрөгийн 10 зөвлөмжийг хүргүүлээ.

Өмнөх оны эхний хагас жилийн статистик мэдээгээр хугацаа хэтэрсэн 658.9 сая төгрөгийн 2 зөвлөмж байсан бол тайлант онд 36.1 сая төгрөгийн 2 зөвлөмж үлдэгдэлтэй байгаа нь өмнөх үетэй харьцуулахад үлдэгдэл 622.8 сая төгрөгөөр буюу 94.5 хувиар буурсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагчийн 14, орон нутгийн төсөвт болон тусгай шилжүүлгийн 124, ОНӨХХК 7, сангийн 30, нийт 175 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн.

ТЕЗ-ийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт 5,253.8 сая төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс 907.3 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулан, 122.6 сая төгрөгийн 1 албан шаардлага 4,223.9 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж хүргүүлэн ажиллалаа. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг дурдвал:

- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын байр ашиглалтын зардлын төсвийг бодитой төлөвлөөгүй,
- Харьяа байгууллагуудын алдаа, зөрчлийн дүн буураагүй, давтагдах шинжтэй
- 2020 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардалд босоо тогтолцоотой байгууллагуудад хөрөнгө оруулалтын ажил хийхээр баталсан байна.
- Аймгийн төрийн сан авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй

Аймгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 83,818.4 сая төгрөгийн орлого, 82,560.1 сая төгрөгийн зарлага, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,400.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2,658.3 сая төгрөгийг аудитаар баталгаажууллаа.

Өмнөх оны хугацаа хэтэрсэн 1 зөвлөмж хэрэгжээгүй үлдэгдэлтэй тайлант онд тогтоосон албан шаардлага болон зөвлөмжийн хэрэгжилтийн хугацаа болоогүй тул хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан

Аудитад төрийн болон орон нутгийн өмчийн 8 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг хамруулж, 7 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 буюу Замын-Үүд НААҮГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлтийг өгсөн.

Аудитаар 12,719.1 сая төгрөгийн 49 алдаа зөрчил илрүүлж, 12,135.1 сая төгрөгийн 15 алдааг залруулан, 71.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэн, 513.3 сая төгрөгийн 31 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтанд өгч ажиллаа.

Тайлант оны аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ангилан харуулбал:

- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 13.6 сая төгрөгийн 16 зөрчил,
- Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 12.135.1 сая төгрөгийн 15 алдаа, 211.8 сая төгрөгийн 10 зөрчил
- Дотоод хяналт, худалдан авалттай холбоотой 359.0 сая төгрөгийн 8 зөрчил байна.

Үүнээс тайлант онд хэрэгжих албан шаардлагын хэрэгжилт хангагдаж, 68.4 сая төгрөгийн 2 албан шаардлага, 214.0 сая төгрөгийн 24 зөвлөмж хэрэгжсэн байна.

Өмнөх оны статистик мэдээгээр хугацаа хэтэрсэн 6,796.8 сая төгрөгийн 23 акт, албан шаардлага, зөвлөмж байсан бол тайлант онд 5,606.1 сая төгрөгийн 22 зөвлөмж үлдэгдэлтэй байгаа нь өмнөх үетэй харьцуулахад үлдэгдэл 1,190.7 сая төгрөгөөр буюу 17.5 хувиар буурсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэл:

Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн сонгуулийн хороонд 16 нэр төрлийн зардалд 419.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос, 333.1 сая төгрөгийг зарцуулж, 8.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитаар сумдын сонгуулийн хороод төсвийг зориулалт бусаар зарцуулсан, зардлын тайланг бодит гүйцэтгэлээр тайлагнаагүй зэрэг зөрчил илэрсэн. Мөн сонгуулийн зардал нь төрийн сангийн гүйлгээний бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний бусад зардлаар хийгддэг тул журамд заасан ангиллаар зарцуулсан эсэхийг хянах боломжгүй байна.



Тайлант онд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний дагуу, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн 5 аудитыг хийв.



Аудитаар нийт 2,156.7 сая төгрөгийн 31 зөрчил



4.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт
2,151.9 сая төгрөгийн 4 албан шаардлага
26 зөвлөмж

3.1. “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт аудит

Аудитад тус аймагт 2020 онд улсын төсвөөр хэрэгжсэн ТАХ-г хамруулан, 2020.03.10-2020.05.18-ны хугацаанд гүйцэтгэлээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 71.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 35 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, 29.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тайлант онд олгохоор шийдвэрлэсэн байна.

Хөрөнгө оруулалтыг салбарын болон орон нутгийн хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан шат шатанд төлөвлөж байгаа ч үр ашгийг тооцож судлаагүй, хөрөнгө оруулалтаас бий болох үр ашиг, нийгмийн болон эдийн засгийн тооцоо судалгаагүйгээр төлөвлөсөн, зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулагдаагүй ажлыг төлөвлөж батлуулснаас ТАХ нь гэрээний хугацаанд хийгдээгүй, ажил чанаргүй хийгдэх зэрэг зөрчил нийтлэг гарсан байна.

Аудитаар нийт 6,938.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 2,151.9 сая төгрөгийн 4 албан шаардлага, 4.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 4 албан тушаалтанд 8 зөвлөмж хүргүүлэв.

Аудитын дүнд үндэслэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд захиалагч, зохиогчийн хяналтын үр дүнг сайжруулах шаардлагатай байна” гэсэн дүгнэлтийг өгөв.

3.2 “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” сэдэвт аудит

Аудитад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ЗДТГ, ХХААГ, ЭМГ, Мал эмнэлгийн газар, Замын-Үүд боомт дахь ХМХА-ыг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитаар зарим үндэсний хөтөлбөрийн хүрээнд дэд хөтөлбөрүүд батлагдаагүй, хэрэгжилт хангалтгүй, төсөв батлагдаагүй, хүнсний аюулгүй байдлын хяналтыг тогтмол хэрэгжүүлээгүй, хүнс, ундны ус, бохир ус, хөрсөнд хүнд металл тодорхойлох шинжилгээ хийгдээгүй, ХМХА-ны зарим тоног төхөөрөмж бүрэн холбогдоогүйгээс химийн бодис, урвалжийн аюулгүй байдал хангагдаагүй, зарим хүнсний худалдааны төвүүд хүнсний агуулах, хөргүүргүй зэрэг зөрчилтэй байна.



Илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ ажиллах тухай 5 зөвлөмж, холбогдох байгууллагад уламжлах 4 асуудлыг УАГ-т хүргүүлээ.

Аудитын дүнд үндэслэн **“Хүнсний аюулгүй байдлыг хянах тогтолцооны үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна”** гэсэн дүгнэлтийг өгөв.

3.3 “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт аудит.

Аудитад аймгийн ЭМГ, МХГ, ЗДТГ-ын холбогдох хэлтэс, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх, худалдах эрх бүхий байгууллагууд, ТББ-ыг хамрууллаа.

Аудитаар төрөөс баримтлах эмийн болон эрүүл мэндийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөрийг баталсан боловч хэрэгжилтийг үнэлээгүй, өндөр өртөгтэй, санхүүгийн дарамт үүсгэх эмнэлгийн хэрэгсэлд болон ядуу эмзэг бүлгийн хүн амд 2018-2020 онд төрөөс дэмжлэг үзүүлээгүй, зарим гэрээ болон санамж бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх ажил хангалтгүй, жор бичилтийн стандарт, эм олгох үйл ажиллагаанд тавьсан хяналт шалгалт, илэрсэн зөрчлийн талаарх баримт, материал хангалтгүй, хяналтын үр дүнг үнэлэх боломжгүй, нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн ЗШЭ-ийн нөөц хангалтгүй, удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлж дуусаагүйгээс эмийн бүртгэл хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй, аймгийн ЭМГ нь эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагуудаас сарын тайлан, сургалт, сурталчилгааны тайлан мэдээг авдаггүйгээс мэдээ тайланг архивлах, нэгтгэх ажил хангалтгүй, аймгийн ИТХ-ын 2017 онд батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг Дорноговь аймагт хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийгдээгүй зэрэг зөрчилтэй байна.




Илэрсэн зөрчлийг арилгах, арга хэмжээ ажиллах тухай 5 зөвлөмжийг 1 албан тушаалтанд, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэхээр 3 асуудлыг УАГ-т хүргүүлээ.

Аудитын дүнд үндэслэн **“Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийн чиглэлээр баримтлах бодлогын хэрэгжилтийг сайжруулах, үр дүнг үнэлэх шаардлагатай байна”** гэсэн

3.4 “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт” сэдэвт аудит.

Аудитад Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д хамаарах аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албыг хамруулан гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Мэргэжлийн хяналтын байгууллагын санхүүгийн хяналт шалгалтын чиг



үүргийг Сангийн яаманд шилжүүлсэн байна. Үүний дагуу аймгийн Засаг даргын 2014 оны А/577 дугаар захирамжаар “Санхүүгийн хяналт, аудитын алба”-ыг 6 орон тоотой байгуулж, аймгийн МХГ-ын санхүүгийн хяналт, шалгалтын байцаагч нар шилжин ажилласан байна.

Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны дүрэмд стандартад заасан шаардлагыг бүрэн тусгаагүй, нэмэлт өөрчлөлт оруулаагүй, мэргэжлийн хүний нөөц дутмаг, зарим ажилчид холбогдох шаардлагыг хангаагүй, санхүүгийн хяналт, дотоод аудитыг стандартад заасны дагуу төлөвлөдөггүй, дунд хугацааны бодлогын баримт бичиг бүрэн хэрэгжээгүй зэрэг зөрчилтэй байна.

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, арга хэмжээ авч ажиллах тухай 7 зөвлөмжийг 2 албан тушаалтанд, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх 2 асуудлыг ҮАГ-т хүргүүллээ.

Аудитын дүнд үндэслэн “Дотоод аудитын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна” гэсэн дүгнэлтийг өгөв.

ДӨРӨВ: НИЙЦЛИЙН АУДИТ



Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-д ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар орон нутгийн гүйцэтгэх аудит тусгагдаагүй байна.

ДӨРӨВ: БУСАД АУДИТ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

4.1 Бусад аудит



Тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд өмнөх онд хийж дуусаагүй 1 нийцлийн аудитыг дуусгахаар төлөвлөсний дагуу аудитыг дуусгавар болгож, 1 эрсдэлийн аудит, өөрийн санаачилгат 3 гүйцэтгэлийн аудит, 1 нийцлийг аудитыг хийхээр төлөвлөн гүйцэтгэлээ.



Аудитаар нийт 5,227.9 сая
төгрөгийн 48 зөрчил



2.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт
376.6 сая төгрөгийн 14 албан шаардлага
4,848.9 сая төгрөгийн 33 зөвлөмж

4.1.1 “Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа” сэдэвт нийцлийн аудит.

Аудитаар төрийн албаны салбар зөвлөлийн 2019-2020 оны үйл ажиллагааг хамруулж тайлагналын үе шатны ажлыг 2021 оны 01 сарын 08-ны өдөр дуусгаж, аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлжээ.

Аудитаар салбар зөвлөлийн гишүүд нь жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн тайлагнаагүй, ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнээгүй, хариуцлага хүлээлгэх асуудал орхигдсон, нөөцийн бүртгэл хөдөлгөөнийг бүрэн хөтлөөгүй, зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах чиг үүргийн хүрээнд 2019 онд 96, 2020 онд 55 албан хаагчид тус нэмэгдлийг олгуулах саналыг гаргасан байна.



Гэвч 2019 оны архивын баримт материалыг гаргаж ирүүлээгүйгээс шаардлага хангасан албан хаагчид олгосон эсэх нь тодорхойгүй, 2020 онд шаардлага хангагдаагүй байхад нэмэгдэл олгосон, 184 сул орон тооны тусгай шалгалтыг зохион байгуулаагүй, ТЖА-ны ажлын байрны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг захиалгын дагуу тухай бүр зохион байгуулаагүйгээс ТЖА-ны нөөцөд бүртгэгдээгүй 47 иргэнийг түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулсан, албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй төрийн албан хаагчдыг тусгай шалгалтад оруулж, нэр дэвшүүлэн томилсон зэрэг зөрчил илэрсэн.

Илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай 8 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажилласан.

Аудитын дүнд үндэслэн “Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна” гэсэн дүгнэлтийг өгөв.

4.1.2 Аймгийн болон Замын-Үүд сумын Онцгой комиссын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, иргэн, ААНБ-аас төвлөрүүлсэн хандивын зарцуулалт” сэдэвт эрсдэлийн аудит.

Аудитад аймгийн болон Замын-Үүд сумын Онцгой комиссын 2020 оны санхүүгийн үйл ажиллагааг хамрууллаа.

Аймгийн Онцгой комисс 2020 онд иргэн, ААНБ-аас нийт 845.3 сая төгрөгийн хандивыг хүлээн авч аймгийн ОБГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, 742.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Харин Замын-Үүд сумын Онцгой комисс иргэн, ААНБ-аас нийт 101.0 сая төгрөгийн хандивыг арилжааны банк



дахь дансанд төвлөрүүлж, 99.2 сая төгрөгийг, тусгаарлалтын төлбөрт 960.7 сая төгрөгийг төвлөрүүлж, 946.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аудитаар Замын-Үүд сумын Онцгой комисс нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр арилжааны банканд данс нээсэн, хууль тогтоомжоор эрх олгогдоогүй албан тушаалтан шийдвэр гаргаж хандивын орлогыг зарцуулсан, тусгаарлалтад хамрагдсан иргэдийн дэлгэрэнгүй судалгаа байхгүй, тусгаарлалтын төлбөрийн тооцоо хийдэггүй зэрэг зөрчлийг ирлүүлсэн. Мөн нягтлан бодох бүртгэлийн журнал хөтөлдөггүй, санхүүгийн тайлан гаргадаггүй, санхүүгийн үйл ажиллагаанд нь тавих хяналтгүй, хувийн дансаар ажил гүйлгээ хийсэн, хандивын хөрөнгөөр худалдан авсан эд хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчилтэй байна.


Илэрсэн зөрчлийг арилгах, таслан зогсоох, хариуцлага тооцуулах тухай 5 албан шаардлага, 4 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн бөгөөд бүрэн хэрэгжсэн байна.

Аудитын дүнд үндэслэн **“Иргэн, ААНБ-аас өгсөн хандивын орлогын бүртгэл, зарцуулалт, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна”** гэсэн дүгнэлтийг өгөв.

4.1.3 “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудит.

Аудитад аймгийн ХХҮГ-ын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019-2020 оны үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитаар сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг бусад эх үүсвэрээс хэрэгжүүлэх ажилтай давхардуулсан, хууль зөрчсөн үйл ажиллагаагаа эрхэлдэг төсөл хөтөлбөрийг сонгон шалгаруулж, санхүүжилт олгосон, хөтөлбөрийн зорилго зорилттой нийцээгүй төслийг шалгаруулсан, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулаагүй төсөл хэрэгжүүлэгчид холбогдох арга хэмжээ аваагүй, төсвийг үрэлгэн зарцуулсан, эргэн төлөлт хийгдээгүй, гэрээний хугацаа дуусаагүй зээлдэгч нараас авлага барагдуулах ажил хийгдээгүй зэрэг зөрчилтэй байна.




Аудитаар нийт 1,643.0 сая төгрөгийн зөрчил илэрч, 2.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 192.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, хариуцлага тооцуулах тухай 4 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх, цаашид анхаарч ажиллах 11 зөвлөмжийг 3 албан тушаалтанд хүргүүлсэн.

Аудитын дүнд үндэслэн **“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг орон нутгийн бодлого чиглэлтэй уялдуулан, үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна”** гэсэн дүгнэлтийг өгөв.

4.1.4 “Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл” сэдэвт гүйцэтгэлийн аудит.

Аудитад аймгийн ТЕЗ-ийн болон ТЗШ-ээр санхүүждэг 106 байгууллага, дулаанаар хангагч 4 ААН, Эрчим хүчний зохицуулах



зөвлөл, СТСХ-ийн 2019-2020 оны түлш, халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, үнэ тариф тогтоох үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитаар халаалтын зардлыг төлөвлөхдөө талбайн хэмжээг төсвийн төсөлд зөрүүтэй тусгасан, халаалтын зардлыг бодитой төлөвлөдөггүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд түлш халаалтын зардлыг зөрүүтэй тайлагнадаг, холбогдох байгууллага, албан тушаалтан хяналт шалгалт хийгээгүй, зардлыг зориулалт бусаар зарцуулсан, ХАА-г зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн, зарим байгууллагын талбайн бодит хэмжилт хийгээгүйгээс зардал бодит тооцооллоос илүү байгаа зэрэг зөрчилтэй байна.

Мөн дулаан хангаж байгаа байгууллага зөвшөөрөлгүйгээр дулаанаар хангах үйл ажиллагаа эрхэлдэг, алба хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх аргачлал боловсруулаагүй зөрчил илэрсэн.

Аудитаар нийт 3,502.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 91.5 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 3,410.5 сая төгрөгийн зөрчилд 9 зөвлөмжийг хүргүүлсэн.

Аудитын дүнд үндэслэн “ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын түлш халаалтын зардлыг эдийн засгийн тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх шаардлагатай байна” гэсэн дүгнэлтийг өгөв.

4.1.5 “Аймгийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит.

Аудитад аймгийн нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн 2019-2020 он болон 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитаар сувилагч, туслах сувилагчийн орон тоо стандартад заасан хэмжээнээс бага, лаборантын орон тоо илүү, зарим шаардлагатай орон тоог батлаагүй, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлээгүй, ажилчдын ажлын гүйцэтгэлийн үнэлэх аргачлал боловсруулаагүй, эмийн хэрэглээ, хангалт, хэрэгцээ шаардлага, хүний нөөцийг бодитой тооцох ажил орхигдсон, ихэнх тасаг нэгжүүд үйлчилгээний өртгөө бүрэн нөхөж чадаагүй, өртөг тооцоогүй, эм,

The image shows the cover page of an audit report. At the top, it says 'ДӨНДӨНШӨН АЙМАГ ДАХЬ ТӨРӨЙН АУДИТЫН ГАЗАР' (General State Audit Agency of the Aimag) and has a logo. Below that, it says 'ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН' (Audit Report) and '“Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үр дүн”' (Summary of the work of the regional general hospital). There is a small text block about the audit period: 'Хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулах шаардлагатай байна.' (Human resources, financial activities need to be managed effectively and organized). Below that, it says 'Аудитын нөдөр: 2021/02/15-2021/03/15'. At the bottom, there is a table with two columns: 'Аймаг' (Aimags) and 'Хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулах шаардлагатай байна.' (Human resources, financial activities need to be managed effectively and organized). The table has two rows: 'Хүний нөөц' (Human resources) and 'Санхүүгийн үйл ажиллагаа' (Financial activities). The 'Хүний нөөц' row has '100000' in the 'Аймаг' column and '100000' in the 'Хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулах шаардлагатай байна.' column. The 'Санхүүгийн үйл ажиллагаа' row has '100000' in the 'Аймаг' column and '100000' in the 'Хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулах шаардлагатай байна.' column.

эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтад хяналт тавиагүй, эмнэлгийн орны тоог өмнөх оны гүйцэтгэлд үндэслээгүй, ор ашиглалт хангалтгүй, үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй зэрэг зөрчилтэй байна.

Илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай 9 зөвлөмжийг хүргүүлсэн.

Аудитын дүнд үндэслэн **“Хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулах шаардлагатай байна”** гэсэн дүгнэлтийг өгөв.

4.1.6 “Газрын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт нийцлийн аудит.

Аудитад аймгийн газар зохион байгуулалтын 2019-2020 он болон 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх үйл ажиллагааг хамруулан дараах зорилтын хүрээнд хийж байна. Үүнд.

- Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлж, ашиглуулах шийдвэр, үйл ажиллагаа хууль, тогтоомжид нийцсэн эсэх,
- Иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, гэрээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа хууль, тогтоомжид нийцсэн эсэх,
- Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд холбогдох байгууллага албан тушаалтан хяналт тавьж холбогдох арга хэмжээг авсан эсэх

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд хийгдэж байна.

4.2 Үүрэг даалгаврын биелэлт

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 108 тушаал гарснаас орон нутгийн ТАБ-д хамаарах 24 тушаал, өмнөх онуудад батлагдан байнга хэрэгжүүлэх 32 тушаалын хэрэгжилтийг тухай бүр ҮАГ-т хүргүүлэн ажилласан.

МУЕА-ын 2021 онд баталсан тушаалын хэрэгжилт

№	Тушаалын дугаар	Хэрэгжилт
1	А/01	Монгол Улсад Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд байгууллагын дарга, тэргүүлэх аудиторовн 2021 оны А/10 дугаар тушаалаар ажлын хэсэг томилогдон ажиллаж байна. Тус ажлын хүрээнд хийсэн ажлыг удирдах ажилтны семинараар өгсөн чиглэлийн хэрэгжилтэд тайлагнасан.

2	A/02	Дарга, тэргүүлэх аудиторов 2021 оны 01 дүгээр сарын 5-ны өдрийн А/02 дугаар тушаалаар байгууллагын албан тушаалын жагсаалт, цалингийн нэмэгдлийг баталсан. Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн А/02, 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/19 дугаар тушаалаар батлагдсан аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагын бүтэц орон тоо, албан тушаалын жагсаалтыг бүх ажилчин албан хаагчдад танилцуулж, бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөн эргүүлэн томилсон тушаалыг ажиллагсдад танилцуулсан.
3	A/03	МУЕА-ын 2021 оны А/02 дугаар тушаал, төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсан. Төлөвлөгөөт аудитуудыг төлөвлөгөөний дагуу хугацаанд нь чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэсэн.
4	A/05	Журмын дагуу 2021 онд А тушаал 45, Б тушаал 15, явуулсан бичиг 686 гаргаж баталгаажуулан, ажилласан.
5	A/09	Төрийн аудитын байгууллагын 2021 онд дэвшүүлсэн "Аудитыг цахимжуулж нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх" зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд холбогдох 2 заалтыг тусган батлуулсан. Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хийгдсэн ажил, аудитын нээлт, тайланг тухай бүр audit.mn болон байгууллагын facebook хуудсанд байршуулан ажиллаа. Мөн 2021 онд гүйцэтгэсэн нийт 206 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын чанарын хяналтыг СТАУС программаар хэрэгжүүлж, дарга, тэргүүлэх аудитор баталгаажуулан ажилласан. Тайлант онд ШТА-ын явцын мэдээг 14 хоног тутамд Teams болон data.audit.mn программаар тайлагнаж ажиллав.
6	A/15	МУЕА-ын тушаалаар батлагдсан аудитын сэдвийг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу СТА-аар нийт 206 байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд санхүүгийн аудит, УАГ-ын нэгдсэн удирдамжаар 4 гүйцэтгэлийн аудит, өөрийн санаачилгаар 3 аудитыг хийж гүйцэтгэсэн ба "Газрын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" сэдэвт аудитын дуусах хугацаа болоогүй байна. Тухайн онд эрсдэлд суурилсан "Аймгийн болон Замын-Үүд сумын Онцгой комиссын 2020 санхүүгийн үйл ажиллагаа, иргэн, ААНБ-аас төвлөрүүлсэн хандивын зарцуулалт" сэдэвт аудитыг хийж гүйцэтгэн тайланг холбогдох байгууллага албан тушаалтанд хугацаанд нь хүргүүлсэн. Мөн "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын гүйцэтгэл"-д аудит хийж гүйцэтгэсэн. Санхүүгийн тайлангийн аудитаар 221 байгууллагын шилэн дансны аудитыг хийж гүйцэтгэсэн.
7	A/16	Аудитын дүгнэлтийн загвар батлах тухай А/16 дугаар тушаалыг мөрдлөг болгон хавсралт маягтын дагуу санал дүгнэлтийг гарган баталгаажуулан ажилласан. Санхүүгийн тайлангийн аудитаар 127 зөрчилгүй, 5 хязгаарлалтай, 1 сөрөг дүгнэлтийг батлагдсан маягтаар гаргасан.
8	A/19	Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/19 дугаар тушаалаар дагуу Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт дарга, тэргүүлэх аудитор 1, аудитын менежер 1, ахлах аудитор 1, аудитор бусад ажилтан 10, нийт 13 орон тоотой ажиллаж байна.
9	A/27	Батлагдсан төлөвлөгөөнд үндэслэн аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 46 ажил, арга хэмжээг тусган батлуулж, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажилласан.

10	A/28	Төрийн аудитын байгууллагаас 2021 онд хийх аудитын төлөвлөгөөнд 206 байгууллагын санхүүгийн тайлангийн аудит, нэгдсэн удирдамжаар хийгдэх 4 аудит, өөрийн санаачилгаар хийгдэх 4 аудит, Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд аудит хийхээр төлөвлөн хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөний дагуу аудит тус бүрт төлөвлөгөөг боловсруулан баталж ажилласан. Мөн 2021 онд хийх аудитын төлөвлөгөөнд тусгагдсан санхүүгийн аудитын хувьд Төсвийн тухай хуульд заасан цагалбарын дагуу санхүүгийн тайлангийн аудит, нэгдсэн удирдамжтай 4 аудит, өөрийн санаачилгаар 3 аудит, эрсдэлд суурилсан 1 аудит, аймгийн сонгуулийн хорооны “Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын гүйцэтгэл”-д аудит хийж гүйцэтгэн холбогдох байгууллага, албан тушаалтан хүргүүлж, олон нийтэд мэдээлсэн.
11	A/29	МУЕА-ын тушаалаар албан хаагчдын үнэлгээг баталгаажуулсныг үндэслэн ҮАГ-аас зохион байгуулсан “Хуулийн хэрэглээ”, “Төрийн аудитын суурь ойлголт, стандартын хэрэглээ” сэдэвт цахим сургалтад 2 албан хаагч хамрагдаж, амжилттай суралцсан. Аудитын сургалтын цахим систем /surgalt.audit.mn/-ээс суралцагч өөрийн сертификатыг татан авч хувийн хэрэгт хийсэн.
12	A/52	2021.05.21-ний өдөр ёс зүйн дүрэм, ёс зүйн зөвлөлийн ажиллах журмын сургалтад нийт 8 албан хаагч хамрагдсан. Шинээр батлагдсан ёс зүйн дүрмийг бүх ажилчдад танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулсан.
13	A/53	2021.05.21-ний өдөр Ёс зүйн дүрэм, Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмын сургалтад нийт 8 албан хаагч хамрагдсан. Уг журамд заасны дагуу ёс зүйн зөвлөлийн гишүүдийг сонгох үйл ажиллагаанд бүх албан хаагч оролцож саналаа өгсөн.
14	A/54	Журмын хүрээнд тусгай шалгалтууд зохион байгуулагдсан ба 2021 оны 5 дугаар сарын 13, 14-ний өдөр 2 аудитор, 2021 оны 10 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд дарга, тэргүүлэх аудитор болон 1 аудитор, 2021 оны 11 сарын 22-нд 2 аудитор тус тус хамрагдаж шалгалтаа амжилттай өгч тэнцсэн. Мөн шалгалтад тэнцсэн хүмүүс цахимаар зохион байгуулсан тангараг өргөх ажилд бүрэн хамрагдсан.
15	A/62	Тус журмын төсөлд 2021 оны 06 сарын 03-ны өдөр 8 санал хүргүүлсэн бөгөөд бүх санал тусгагдсан.
16	A/69	Ерөнхий аудиторын 2021 оны 06 сарын 18-ны өдрийн А/69 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал"-ын дагуу нэгдсэн удирдамжаар "Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн", "Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт", "Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр дүн" сэдэвт аудитуудыг гүйцэтгэж, хавсралт маягтын дагуу баримт материалыг бүрдүүлэн ажилласан.
17	A/70	2021 оны санхүүгийн тайлангийн завсрын буюу төлөвлөлтийн үе шатны ажлыг хийж батлагдсан журам маягтын дагуу ажлын баримтыг бүрдүүлэн ажиллаж байна.
18	A/71	Өөрийн санаачилгаар "Газрын тухай хуулийн хэрэгжилт" сэдэвт нийцлийн аудитыг тус журам заасан заавар аргачлалын дагуу төлөвлөгөө боловсруулж, аудитыг гүйцэтгэж байна
19	A/82	Журам батлагдсанаар ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”, "Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт", "Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр дүн", "Газрын тухай хуулийн хэрэгжилт" сэдэвт аудитын хүрээнд аудитын үр өгөөжийн урьдчилсан төлөвлөлтийг аудит бүрд хийж баталгаажуулан, бүртгэл, тайлагналыг тухай бүр хийж гүйцэтгэсэн.
20	A/87	Аймгийн хэмжээгээр нийт 232 байгууллага санхүүгийн тайлангийн аудитад хамруулахаас 67 байгууллагыг хувийн аудитын компани, 165 байгууллагыг төрийн аудитын байгууллага хийхээр байгууллагын жагсаалт, аудит хэлбэрийг тодорхойлж батлуулсан
21	A/101	Ойн арга хэмжээний бэлгэдлийг тухайн арга хэмжээтэй холбоотой бүхий л арга хэмжээнд хэрэглэхээр төлөвлөж байна. Мөн аймгийн номын эх бэлтгэх ажилд ашиглаж байна.
22	A/104	Аудитын сэдэв сонгох ажиллагааны журамтай бүх аудитууд танилцан судалсан.
23	A/105	МУЕА-ын баталсан журмын дагуу аймаг Төрийн аудитын газрын 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж байна.

24	A/108	Тус журмыг завсрын болон төлөвлөлтийн үе шатны ажилд хэрэгжүүлэн ажиллаж, 20 байгууллагын 2021 оны шилэн дансны үйл ажиллагааг хянаад байна.
----	-------	--

Удирдах ажилтны семинараас өгсөн дараах 6 чиглэл ажлыг хэрэгжүүлэн ажилласан.

- Албан хаагч бүр албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, 7 хоног бүрийн даваа гариг бүр өмнөх 7 хоногт хийсэн ажил, энэ 7 хоногт хийгдэх ажлаа ярилцан, удирдлагаас үүрэг даалгавар өгч ажиллаж байна. Ажилчдын 4-р улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг МУЕА-ийн тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үр дүнг үнэлэх” журмын дагуу дүгнэн ажлыг эрчимжүүлэхэд анхаарч ажиллалаа.
- Байгууллагын улирал бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гарган хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний ажлын уялдаа холбоог судлан дараа улирлын гүйцэтгэлд хяналт хийн ажилласны үр дүнд 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.
- Аудитын үйл ажиллагааг шинэ шатанд гаргах чиглэлээр аудитын багийн боловсруулсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шат бүрд хамт олны хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж, аудитын үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллаа. Мөн “Байгууллагын соёл” сэдвээр нийт ажилчдад дотоод сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж бүх албан хаагчдыг хамруулан сургалтын үр дүнгийн талаар судалгаа авсан. Шинэ аудитораар томилогдсон аудиторуудыг ажлын туриллагатай аудиторт хариуцуулан ажилласны үр дүнд аудиторууд ажилдаа идэвх санаачилгатай байж, ажлын бүтээмж дээшилж байна.
- Аудитын нээлт болон тайлангийн хурлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Аудитын төгсгөлийн уулзалтаар аудитын санал дүгнэлт өгсөн зөвлөмж, албан шаардлагыг танилцуулан холбогдох шалтгаан тайлбарыг гаргуулан авч аудитын тайланд тусган ажилласан.
- Үндэсний аудитын газар, аймаг нийслэл дэх төрийн аудитын газруудын болон бүтцийн нэгжүүдийн хооронд мэдээллийг ABLE программ болон VIBER-аар дамжуулан солилцож байна. Байгууллага дотроо ABLE программыг бүрэн нэвтрүүлж ажил хэрэг, албан бичиг, олон нийт, бусад цэсийг ашиглан албан тоот, тушаал шийдвэр, үүрэг даалгаврын мэдээллийг байнга солилцон ажиллаж байна.
- Монгол Улсад Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой ажлыг зохион байгуулах хүрээнд дарга, тэргүүлэх аудиторын 2021 оны А/10 тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилон ажиллаж байна.
- Ойг угтан ажилчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр 10.0 сая төгрөгийн дэмжлэгээр байгууллагын 3 албан тасалгааг засварлалаа.
- Үндэсний аудитын газраас өгсөн чиглэлийн дагуу төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн номын эх бэлтгэх ажлыг хийв. Тус эхэд 1995-2021 онд ажиллаж байсан үе үеийн дарга, ерөнхий аудитор, тэргүүлэх аудитор, Хянан шалгах хорооны гишүүн, ахмад ажилтан нарын дурсамж танилцуулга, байгууллага хамт олны тухай болон бүсийн сургалт, тэмцээн уралдаан, байгууллагын амжилт, 1995-2003 он болон 2003-2021 онуудын хийж гүйцэтгэсэн ажлын тоон үзүүлэлт, ажиллаж байсан ажиллагсдын жагсаалтыг гарган хүргүүлсэн.
- Ажилчдыг нэгэн ижил жигд хувцастай болгох ажлын хүрээнд бүх ажилтны саналаар загвараа сонгон Monline ХХК-д төрийн аудитын байгууллагын brand book өнгө, загвараар сэрүүн улиралд өмсөх хувцас хийлгэхээр захиалга өгөөд байна.

ЗУРГАА: ДОТООД АЖИЛ



Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг дэмжих дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

6.1 Дотоод сургалт:

Бүтэц зохион байгуулалтын шинэчлэлийн хүрээнд байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөг албан хаагчдаас ирүүлсэн санал, тэдний ур чадвар, чадавхыг сайжруулах хэрэгцээ шаардлага болон УАГ-ын сургалтын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, баталж, хэрэгжилтийг ханган ажиллаа.

Төлөвлөгөөнд байгууллагын албан хаагчдаас зохион байгуулах 12 сургалт, мэргэжлийн байгууллага, багштай хамтран зохион байгуулах 2 сургалтыг тусгаж, тайлант хугацаанд төлөвлөгөөт сургалтыг бүрэн зохион байгууллаа. Үүнд:

- *ХАСХОМ мэдүүлэх тухай, анхаарах асуудал*
- *Аудитын үр өгөөжийн бүртгэл, төлөвлөлт*
- *Ажлын цаг ашиглалт*
- *Байгууллагын соёл*
- *Гүйцэтгэлийн аудитад нотлох зүйлийг үнэлэх, дүн шинжилгээ хийх заавар*
- *ТАБ-ын “Төрийн аудит” MNS стандартууд, тулгаар зарчим*
- *Аудитын тоон мэдээллийг боловсруулах шинжилгээний программ хангамжийн хэрэглээ*
- *Төрийн аудитын байгууллагаас гаргасан захиргааны актыг биелүүлээгүй нөхцөлд хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх нь*
- *Аудитад түүвэрлэлтийг ашиглах арга зүй, заавар*
- *Баримт бичгийн стандарт-MNS 5140:2021 сэдвүүдээр зохион явууллаа.*

Ковид-19 цар тахлын үед танхимыг сургалтыг явуулах боломжгүй байдал үүссэн тул зарим сургалтыг цахимаар явууллаа.

Мөн ТЕГ-ын Дорноговь аймаг дахь Тагнуулын хэлтэстэй хамтран “Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж”, аймгийн “Насан туршийн боловсролын төв”-тэй хамтран монгол бичгийг сургалтыг зохион байгууллаа.

Байгууллагын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор дотоод сургалтаас гадна дараах сургалтад хамрагдан албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна. Үүнд:

- *Сангийн яамнаас зохион байгуулсан “Засгийн газрын худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох” цахим сургалтад аудитын менежер У.Оюунтүлхүүр, аудитор Ч.Хэрлэнчимэг, Б.Уранбилэг, Л.Равдандорж, Т.Мөнхтогтох, Д.Дэмбэрэлсүрэн нар хамрагдан шалгалт өгч АЗ гэрчилгээ авсан.*
- *ММНБИ-ээс зохион байгуулсан “Аудитор”-ын сургалтад дарга, тэргүүлэх аудитор хамрагдан амжилттай суралцаж төгссөн.*
- *Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт цахим сургалтад дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер болон 4 аудитор хамрагдаж, амжилттай суралцсан.*
- *ММНБИ-ээс зохион байгуулсан “Мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалт”-д дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер болон 2 ахлах аудитор, 2 аудитор хамрагдаж, мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлсэн.*
- *Удирдлагын Академиас зохион байгуулсан “Алсын хараа-2050” сэдэвт цахим сургалтад дарга, тэргүүлэх аудитор болон аудитын менежер нар хамрагдаж, гэрчилгээ гардан авсан.*
- *“Тод” санхүү, бизнесийн академиас зохион байгуулсан “Өртөг ба гүйцэтгэлийн удирдлага” цахим сургалтад аудитор Ч.Хэрлэнчимэг хамрагдсан.*
- *Удирдлагын Академийн Төрийн удирдлагын магистрын ангид аудитор Ч.Хэрлэнчимэг суралцаж байна.*
- *УАГ-аас зохион байгуулсан “Хуулийн хэрэглээ /Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга/” сэдэвт цахим сургалтад 2 албан хаагч хамрагдаж, амжилттай суралцсан.*

- *ҮАГ-аас зохион байгуулсан “Төрийн аудитын суурь ойлголт, стандартын хэрэглээ” сэдэвт цахим сургалтад 2 албан хаагч хамрагдаж, амжилттай суралцсан.*
- *ҮАГ-аас зохион байгуулсан шилэн дансны цахим систем болон статистик мэдээ, бүртгэл, нэгтгэлийн системийн тухай ойлголт, МУЕА-ын шинээр баталсан дүрэм, журмын танилцуулгын талаарх мэдээлэл өгөх сургалтуудад байгууллагын бүх албан хаагчид хамрагдсан.*
- *Тагнуулын ерөнхий газраас зохион байгуулсан “Төрийн болон албаны нууцын хууль тогтоомжийн мэдлэг олгох цахим сургалт”-д байгууллагын нууц хамгаалах ажилтан хамрагдсан.*
- *ҮАГ болон МУЕПГ-тай хамтран зохион байгуулсан “Аудитын явцад илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулах нь” цахим хэлэлцүүлэгт нийт алба хаагчид бүрэн хамрагдсан.*
- *Төрийн аудитын сургалт, хөгжлийн систем дэх “Эдийн засгийн бодлогын шинжилгээ” цахим сургалтад бүрэн хамрагдаж, явцын сорилыг амжилттай өгсөн.*
- *ҮАГ болон АТГ-тай хамтарсан “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” мэдлэг олгох цахим сургалтад дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер болон 2 аудитор хамрагдсан.*
- *ҮАГ-аас зохион явуулсан “Аудитын үйл ажиллагаанд захиргааны ерөнхий хуулийг хэрэглэх нь” цахим сургалтад дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер болон 2 аудитор хамрагдсан.*
- *ҮАГ-аас зохион явуулсан “Архив, албан хэрэг хөтлөлт” сургалтад нийт алба хаагчид хамрагдсан.*

Архив, бичиг хэрэг:

Архив, албан хэрэг хөтлөх ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэлээ.

- *Тайлант онд нийт 625 албан бичиг ирж, бусад байгууллага албан тушаалтанд 662 албан бичгийг хүргүүлсэн байна.*
- *Байгууллагын үйл ажиллагаа болон хүний нөөцтэй холбоотой “А” тушаал 45, “Б” тушаал 14 тус тус гарсан байна.*
- *Ирсэн болон явсан бичгийн хариу ирүүлэх хугацааг ABLE программд тэмдэглэж, хяналт тавин ажиллаж байна.*
- *Ирсэн болон явсан бичгийг бичиг хэргийн ажилтан тухай бүр сканердаж, цахим сан /архив/ үүсгэж байна.*
- *Байгууллагын албан хэрэг хөтлөх үйл ажиллагааг хууль журамд нийцүүлэх зорилгоор БНШК хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, аймгийн Архивын газраар батлуулсан.*
- *Байгууллагын байнга хадгалагдах архивын нэгжүүдийг төрийн архивд шилжүүлэх ажил хийгдэж байна.*
- *Аймгийн Засаг даргын нэрэмжит “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үзлэг”-т хамрагдан 92 хувьтай үнэлэгдсэн.*

Өргөдөл, гомдол шийдвэрлэлт:

Тайлант онд байгууллагын алба хаагчдаас нийт 17 өргөдөл ирүүлснийг тухай бүр шийдвэрлэж ажиллаа. Харин бусад байгууллага, иргэнээс өргөдөл, гомдол, хүсэлт ирээгүй байна.

Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа:

Монгол улсад Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд байгууллагын өнгө үзэмж, алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилгоор дараах ажлуудыг хийг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аймгийн Засаг даргын дэмжлэг болон байгууллагын урсгал засварын зардлаар нийт 12.9 сая төгрөгөөр 3 албан тасалгааг завсарлав.



- Байгууллагын техник хэрэгслийн сайжруулах, үзүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор батлагдсан төсвийг хүрээнд 5 суурин компьютер, 4 ширхэг 3 үйлдэлт принтер худалдан авсан.
- ТАБ-ын Хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн аудитор Ч.Хэрлэнчимэгт магистрын сургалтын төлбөрийн хөнгөлөлт, аудитор Б.Уранбилэгт орон сууцны нөхцөлөө сайжруулахад мөнгөн дэмжлэг, ахлах аудитор О.Нарангаравт хүүхдийн эмчилгээний зардалд дэмжлэг, шинэ хүүхэдтэй болж бүл нэмсэн аудитор Л.Равдандоржид нэг удаагийн буцалтгүй тусламжийг тус тус олгож, албан хаагчдын зарим нийгмийн асуудлыг төсвийн хүрээнд шийдвэрлэсэн.
- Жил бүр тохиох Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр болон шинэ жилийн баяраар байгууллагын албан хаагчдын үр хүүхдүүдэд бэлэг гардуулж занисан ба тайлант оны 6 дугаар сарын 1 болон 12 дугаар сарын 31-ны өдрүүдэд албан хаагчдын 24 хүүхдэд, уламжлалт “Цагаан сар”-ын баяраар байгууллагын ахмадуудад төсвийн хүрээнд бэлэг гардуулсан.
- Албан хаагчид өөрсдийн мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгоор суралцсан албан хаагчдад байгууллагаас сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал, “Мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалт”-д хамрагдсан 5 албан хаагчдад тус бүр 40.0 мянган төгрөгийн, Засгийн газрын худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох” сургалтад хамрагдаж, амжилттай суралцсан 5 албан хаагчдад тус бүрд сургалтын төлбөр болох 70.0 мянган төгрөгийн дэмжлэгийг тус тус өгсөн.
- Байгууллагын албан хаагчдын чөлөөт цагийг зөв, үр бүтээлтэй өнгөрүүлэх үүднээс 7 хоног бүрийн Мягмар гарагт гар бөмбөг, сагсан бөмбөгийн спортоор хичээллэж байна.
- Ковид-19 цар тахлын тархалт ихэссэн энэ хүнд үед албан хаагчдыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Верацелл вакциныг 2 тунд хамруулж, 1, 6 дугаар саруудад 2 удаа витаминжуулж, дархлааг дэмжих арга хэмжээ авч ажиллаад байна.
- Цар тахалтай холбоотойгоор ажиллагсдыг халдварт өвчнөөс хамгаалах зорилгоор нүүрний хаалт, нэг удаагийн резинэн бээлий, гарын цаас, ариутгагчтай нойтон салфетик, албан тасалгааг ариутгах мананцаржуулагч буу, ариутгалын бодисыг худалдан авсан.

Хүний нөөц, шагнал урамшуулал, амжилт, харилцаа, хамтын ажиллагаа

Тус байгууллагад жинхлэн томилогдсон дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий, тусгай шалгалтад тэнцсэн ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Л.Равдандорж, шинээр томилогдсон аудитор Д.Дэмбэрэлсүрэн, Б.Ариунбаатар, Б.Алтанзул нар “Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн тангараг” өргөлөө.



Санхүү эдийн засгийн алба үүсэн байгуулагдсаны 110 жилийн ойн хүрээнд аймгийн бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтнуудын дунд зохион байгуулагдсан спортын олон төрөлтийн тэмцээнд багаараа 2 дугаар байр эзэлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа. Тэмцээний “Гар бөмбөг” төрөлд алтан медаль, “Сагсан бөмбөг” төрөлд 4 дүгээр байр, “Теннис-эмэгтэй” төрөлд хүрэл медаль, “Теннис-эрэгтэй” төрөлд мөнгөн медаль, “Дартс” төрөлд хүрэл медаль тус тус хүртлээ.



Мөн Төрийн аудитын газрын байрладаг албан байранд зэрэгцэн ажиллаж байгаа аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Санхүүгийн хяналт, аудитын албаны албан хаагчдын дунд зохион байгуулагдсан нөхөрсөг гар бөмбөгийн тэмцээнд “Тэргүүн” байр эзэлсэн.



Аймгийн СТСХ-ээс зохион байгуулсан орон нутгийн байгууллагуудын нягтлан бодогчдыг мэргэшүүлэх сургалтад аудитор Ч.Хэрлэнчимэг СТА-ын алдаа зөрчил, 2022 онд хийх санхүүгийн тайлангийн аудитаар анхаарах асуудлын талаар мэдээлэл хийв.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “10 сая мод” арга хэмжээнд нэгдэж, мод тарив.





Тайлант онд албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж, амжилттай ажилласан зарим албан хаагчийг орон нутгийн захиргааны байгууллага болон ТББ-ын шагналт тодорхойл шагнууллаа. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын өргөмжлөлөөр аудитын менежер У.Оюунтүлхүүр, жолооч Ч.Батцэнгэл
- Сайншанд сумын ИТХ-ын өргөмжлөлөөр аудитор Т.Мөнхтогтох
- Сайншанд сумын Засаг даргын өргөмжлөлөөр аудитор Б.Уранбилэг
- Монголын эмэгтэйчүүдийн холбооны хүндэт тэмдгээр үйлчлэгч Б.Нарантуяа
- Монголын залуучуудын холбооны “Тэргүүний залуу” медалиар бичиг хэрэг Э.Бат-Оргил нар шагнагдав.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд:

Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаа. Үүнд:

- Хуульд заасан албан тушаалтнууд 2020 оны ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд, шинээр томилогдсон аудиторуд 30 хоногийн дотор мэдүүлж, байгууллагын ЭБАТ системд баталгаажуулсан.
- Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийсэн ажлын тайланг 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор УАГ-ын ЭБАТ-д, 12 дугаар сарын 01-нд МУЕА-ын орлогчид тус тус хүргүүлсэн.
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "... албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана" гэж заасны дагуу аудитор бүр санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитыг хийж гүйцэтгэхийн өмнө холбогдох мэдэгдлийг гарган дарга, тэргүүлэх аудитор баталгаажуулсан.
- Төрийн хяналт, шалгалтын стандартыг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмжийн 01 дүгээр хавсралтын дагуу аудит хийхийн өмнө сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг аудитор, аудитын менежер, дарга, тэргүүлэх аудитор тухай бүр гаргасан.
- Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хүрээнд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн мэдээлэл сурталчилгаа, иторкыг байгууллагын social цахим хуудсаар байршуулан сурталчилж байна.



- Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх, авлигаас ангид байх ажлын хүрээнд авлигын эсрэг мэдээллийн самбарыг тогтмол шинэчилж, албан тасалгаа бүрийн үүдэнд зурагт сурталчилгааг байршуулсан.
- Аудитын нээлт бүрд шалгагдагч байгууллагад аудитын төлөвлөгөө болон төрийн аудитын байгууллагын мэдээлэл авах эрх, шалгагдагч байгууллагын үүрэг, нөлөөллийн мэдүүлэг, авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгддэг ажлын талаарх холбогдох мэдээллийг танилцуулан ажиллаж байна.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд.

Хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг хангаж ажиллаа.
Үүнд:

- Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл агуулсан баримтыг албан хэрэг хөтлөх зааврын бүртгэн, архивын нэгж үүсгэн ажилласан.
- Төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан баримтыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган баталгаажуулсан.
- Төрийн болон албаны нууцын хүрээнд хийсэн ажлын тайланг холбогдох журамд заасан хугацаанд хүргүүлсэн.
- Төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгааг 2021 оны 01 дүгээр сард бүх алба хаагчдаар гаргуулсан.
- Төрийн болон албаны нууц тээгчийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хадгалах, хамгаалах ажил хийгдэж байна.


Мэдээллийн ил тод байдлын хангах ажлын хүрээнд.

Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг “Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар” facebook хуудсаар, аудитын тайлан, үндсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг audit.mn цахим хуудсаар, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг “Шилэн дансны нэгдсэн систем”-д тухай бүр мэдээлж мэдээллийн ил тод байдлыг хангаж

ажиллаа.



ДОЛОО: САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ



Тайлант онд 483.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 483.2 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 432.1 сая төгрөгийг зарцуулсан. Мөн нэмэлт санхүүжилтийн дансанд аудитын үйлчилгээний төлбөрт нийт 66.4 сая төгрөг, аймгийн ИТХ-аас 2.6 сая төгрөгийн дэмжлэг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 10.0 сая төгрөгийн дэмжлэг, акталсан хөрөнгө борлуулсны орлого 60.0 мянган төгрөг, даатгалаас 0.3 сая төгрөг тус тус төвлөрсөн. Үүнээс гэрээгээр ажил гүйцэтгэсэн хувийн аудитын компаниудад 66.3 сая төгрөг, байгууллагын албан хэрэгцээний автомашинд сэлбэг худалдан авах, урсгал завсарт 2.9 сая төгрөг, 2.6 сая төгрөг, албан тасалгааны засварт 10.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Мөн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Санхүүгийн тайланг улирал бүр гарган баталгаажууллаа.
- Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, татварын болон НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу байгууллагын эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллогыг дарга, тэргүүлэх аудиторовн тушаалаар ажлыг хэсгийг томилон гүйцэтгэлээ.
- Байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд “Мишээл-Од аудит” ХХК аудитыг хийж гүйцэтгэн “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн. Аудитын тайланд 7.4 сая төгрөгийн 5 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаа.

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хөтөлж, 2019 оноос НББ-ийн үйл ажиллагаанд санхүүгийн “Unicus” программыг ашиглаж байна.

НАЙМ: ДҮГНЭЛТ, САНАЛ



Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар батлагдсан ТАБ-ын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, 2021 онд дэвшүүлсэн зорилтыг баримтлан ажиллаа.

- Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, стратегийн хүрээнд нийт 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг бүрэн хэрэгжүүлсэн.
- Тайлант онд санхүүгийн тайлангийн аудит 221, ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудит 1, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэл” аудит 1, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит 4, өөрийн санаачилгат гүйцэтгэлийн аудит 3, нийцлийн аудит 1, өмнө онд дуусгаагүй нийцлийн аудит 1, эрсдэлийн аудит 1, нийт 233 аудит хийж гүйцэтгэлээ.
- Тайлант онд хэрэгжиж дуусах 29.9 сая төгрөгийн 22 төлбөрийн актаас 29.5 сая төгрөгийн 21 төлбөрийн акт бүрэн хэрэгжиж 98.7 хувь, 5,788.5 сая төгрөгийн 84 албан шаардлагаас 4,573.3 сая төгрөгийн 67 албан шаардлага бүрэн хэрэгжиж 79.0 хувь, 7,947.4 сая төгрөгийн 274 зөвлөмжөөс 7088.1 сая төгрөгийн 200 зөвлөмж хэрэгжиж 89.2 хувийн биелэлттэй байна. Хэрэгжих хугацаа болоогүй 1 албан шаардлага, 3409.1 сая төгрөгийн 29 зөвлөмж байна.
- Өмнөх оноос шилжиж ирсэн үлдэгдэл 25.7 сая төгрөгийн 22 төлбөрийн акт, 7,382.4 сая төгрөгийн 40 албан шаардлага, 11,332.5 сая төгрөгийн 118 зөвлөмж байснаас тайлант онд төлбөрийн акт 23 хувь, албан шаардлага 55 хувьтай, зөвлөмж 57 хувьтай хэрэгжсэн.
- Тайлант онд хийж гүйцэтгэсэн аудитаар нийт 712.6 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөн, хүлээн зөвшөөрүүлж, орон нутгийн 2022 оны төсвийн төсөлд 1,000.0 сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлэн батлуулж, нийт 1,712.6 сая төгрөгийн үр өгөөж тайлагнан ажиллаа.
- Байгууллагын үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомжийг мөрдөж ажиллав.

Тайлант оны үйл ажиллагаатай холбоотой дараах саналыг хүргүүлж байна. Үүнд.

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасан хугацаанд ирүүлэх.
2. Нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх аудитыг хэт богино хугацаанд гүйцэтгэхээр ирүүлж байгаа нь аудитын чанаргүй гүйцэтгэх эрсдэлийг үүсгэж байгааг анхаарах.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд ойрын олон хэтийн бодлого, төлөвлөгөөнд тусгах санал санаачилгатай холбоотой

1. Албан хаагчдыг гадаадын сургалтад үе шаттайгаар хамруулж, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлснээр аудитыг илүү үр өгөөжтэй, үр нөлөөтэй гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.

ЕС. ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

1. Байгууллагын 2021 оны статистик мэдээ
2. Аудитаас бий болсон үр өгөөжийн тайлангийн нэгтгэл

ХЯНАСАН:



Хаяг: Сайншанд сумын 3 дугаар баг
Орон нутгийн өмчийн 3дугаар байр
Утас: 70522734, 70523020
И-мэйл: dornogovi@audit.gov.mn